

# 2020 / 2021 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН 1-Р АНГИЙН ЭЛСЭЛТИЙГ ХҮҮХЭД ОРОЛЦОХГҮЙГЭЭР БҮРТГЭНЭ

Боловсрол, залуучууд, спортын яамнаас коронавирус ба COVID-19 өвчний эсрэг авч буй онцгой арга хэмжээтэй уялдуулан 2020/2021 оны хичээлийн жилийн нэг дүгээр ангид элсэх бүртгэлийн талаар арга хэмжээг авч байна. Элсэлтийн бүртгэл нь 4 сард хүүхдүүдийг сургуульд авчрахгүй ба оролцоогүйгээр явагдана.

Сургуулийн хуулийн дагуу манай сургууль **2020 оны 4 сарын 1-нээс 2020 оны 4 сарын 30 хүртэл** элсэх бүртгэлийг хийнэ.

Дээрх арга хэмжээг авахад дараах зүйлийг шаарддаг:

- Сургууль дээр хүүхдийг авчрахгүй, оролцоогүйгээр бүртгэлийн ажиллагааг зохион байгуулна.
- Сургуульд бүртгүүлэх хүсэлтийг хүүхдийн хууль ёсны асран хамгаалагч өөрөө оролцохгүйгээр (мэдээллийн хайрцаг, цахим гарын үсэгтэй имэйлийн хаяг), эсвэл шаардлагатай бол сургууль дээр биечлэн ирж эсвэл шуудангаар хийж болно.

## Өргөдөл гаргах

Өргөдлийг дараах байдлаар хүргэх боломжтой :

- сургуулийн мэдээллийн шуудангаар
- имайлаар цахим гарын үсэгтэй (зөвхөн имайлаар явуулж болохгүй!)
- шуудангаар:

Хүүхдийн хууль ёсны төлөөлөгч нь сургуульд өргөдөл гаргахдаа сургуулийн хуулийн 37 –ийн 2-р хэсэгт зааснаар эдгээр зүйлийг бүрдүүлнэ:

- хүүхдийн нэр ба овог
- төрсөн огноо
- байнга оршин суудаг хаяг, эсвэл захидал авах хаяг ( § 19-р хуулийн 3 хэсгийн дагуу)
- өргөдөл гаргаж байгаа сургуулийн хаяг (ямар сургууль),
- өргөдөл гаргасан хүний гарын үсэг (хууль ёсны төлөөлөгчийн гарын үсэг)
- сурагчийн хууль ёсны төлөөлөгчийн нэр, овог
- хууль ёсны төлөөлөгчийн байнга оршин суудаг хаяг, эсвэл захидал авах хаяг

Жич: Хэрэв хүүхдийг хууль ёсны төлөөлөгчөөс өөр хүн төлөөлж байгаа бол тэр хүүхдийг төлөөлөх бүрэн эрхийг нотлох баримт.

Жич: Сурагчийн хууль чсны төлөөлөгч имэйл хаяг, утсаа бичнэ үү. Таны өргөдөлийг хүлээн авсан эсэх, бүх зүйл асуудалтай эсэхийг танд мэдээллэх болно.